ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 03 өдөр Дугаар А/173 Мөрөн сум

Хөрөнгө актлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.9, 52.1.12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3, 4 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 88 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Мөрөн сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн шинэ барилгын ажлын гэрээ байгуулагдаж, эхлэх болсонтой холбогдуулан тус цэцэрлэгийн эрхлэгчийн хүсэлт, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын захирамжийг тус тус харгалзан хүүхдийн аюулгүй, эрүүл орчинд сурч хөгжих боломжийг хангах хүрээнд Орон нутгийн өмчит хуулийн этгээд Мөрөн сумын 2 дугаар цэцэрлэгийн эзэмшилд байгаа ашиглах боломжгүй актлах барилга байгууламж 139,290,726.20 (Нэг зуун гучин есөн сая хоёр зуун ерэн мянга долоон зуун хорин зургаан төгрөг хорин мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг хавсралтаар баталж, хөрөнгийг актлах ажлыг зохион байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт дор дурьдсан арга хэмжээг авч ажиллахыг үүрэг болгосугай.

2.1 Акталж, данснаас хасах хөрөнгөөс ашиглаж болох эд зүйлийг ялган тоолж, үнэ тогтоон эргэлтийн хөрөнгийн бүртгэлд тусган ашиглах, тогтоосон журмын дагуу худалдан борлуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгах;

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Одончимэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.МӨНГӨНХУЯГ

Аймгийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын даргын
2024 оны 09 дүгээр сарын 03-ны
өдрийн А/73 дугаар захирамжийн
хавсралт

Барилга, байгууламж, нийтийн эзэмшил актлах

№	Аймаг, сумын нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ /төг/	Байгуулсан элэгдэл /төг/	Үлдэгдэл үнэ /мян.төг/	Тайлбар	Байгуулагын санал /төг/	Орон нутгийн өмчийн газрын үнийн санал /төг /	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэр /төг /
1	Мөрөн	Мөрөн сумын хүүхдийн Хоёрдугаар цэцэрлэг	Цэцэрлэгийн барилга	1969	м2	825.8	238,784,102.00	99,493,375.80	139,290,726.20	Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны 08 сарын 20-ны өдрийн 38 дугаар захирамж	Актлах	Актлах	Актлах
Дүн							**238,784,102.00**	**99,493,375.80**	**139,290,726.20**				

оОо